



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

122 /122/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.08.27

ҮЙЛ ЯВДАЛ

“ЦЭРГИЙН РАЛЛИ-2021” МЕДАЛИЙН БУУХИА ҮРГЭЛЖИЛСЭЭР



Өчигдөр буюу энэ сарын 26-ны өдөр “Цэргийн ралли-2021” тэмцээний 3 дугаар шатны багийн буудлага (5.45 мм-ийн АКМС-74)-ын ангилалд 7 улсын 28 багийн 56 цэргийн алба хаагч өрсөлдсөнөөс “КамАЗ-4х4”

ангиллын чиглүүлэгч, дэслэгч М.Шийрэвноров 95 оноогоор алтан медаль хүртлээ.

Баг тамирчид маань энэ сарын 27-ны өдөр зохион байгуулагдах 4 дүгээр шатны багийн уралдааны ангилалд

“КамАЗ-4х4”, “Урал-4х4”, “КамАЗ-6х6”, “Урал-6х6” загварын автомашинуудаар нэг баг болон өрсөлдөх бөгөөд техникийн болон байр зүйн бэлтгэлийг бүрэн хангаад байна.

“Цэргийн ралли-2021” олон улсын тэмцээнд оролцож 3 алт, 2 хүрэл медаль хүртээд буй Монгол Улсын Зэвсэгт хүчний баг тамирчдын маань амжилтын буухиа үргэлжилсээр.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
14	2

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
31	25

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.849.0	2.852.0
EUR	3.351.0	3.360.0
CNY	440.0	441.0
RUB	37.80	39.00
JPY	25.73	26.17
KRW	2.39	2.48

ЗУРХАЙ

2021.08.27 ПҮРЭВ ГАРАГ
/БИЛГИЙН ТООЛЛЫН 20/

НАМРЫН ТЭРГҮҮН УЛААН БИЧ САРЫН ГУРВАН ХӨХ УЛААЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:
Өлсөж ундаасна
Наран ургах, шингэх:
06.04-19.44
Барилдлага:
Үл тохирох
Шүтэн барилдлага:
Нэр өнгө
Суудал:
Хий

Тухайн өдөр гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба лусыг тахиж, тангараг тавих, гэр, байшингийн суурь тавихад сайн.

Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, сэтгэлд сэвтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсоод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал “өлсөж ундаасна” хэмээжээ.

ЦЭРГҮҮД ТОГООЧИЙН КУРСТ ХАМРАГДАВ

Монгол Улсын Засгийн газраас 2021 онд гаргасан ажилгүйдэлтэй тэмцэх, залуучуудыг ажил мэргэжилтэй болгох төслийн хүрээнд Зэвсэгт хүчний Жанжин штаб “Монголын ресторан зоогийн газрын холбоо”-той хамтран Улаанбаатар цэргийн хүрээний нэгтгэл, ангиудын хугацаат цэргийн алба хаагчидтай 10 хоногийн тогоочийн сургалтыг Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн байрлалд зохион байгуулав.

Сургалтад Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл, 014, 015, 120, 326 дугаар ангиудын 40 гаруй хугацаат цэргийн алба хаагч өөрсдийн хүсэлтээр хамрагдаж амжилттай төгссөн юм.

Төгсөлтийн ёслолын ажиллагаанд Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн захирагч, бригадын генерал Т.Лодойдамба,

“Монголын ресторан зоогийн газрын холбоо”-ны дэд захирал С.Батбаатар, “Гүн шим” рестораны захирал Ш.Эрдэнэхүү, ШУТИС-ийн технологич багш Н.Долгорсүрэн, “Модерн номадс” рестораны ерөнхий тогооч Л.Алтаншагай, Б.Бархассүрэн, Хүнсний үйлдвэрийн дарга Г.Соёлмаа нар оролцож, амжилттай суралцсан алба хаагчдад сертификат гардуулав.

Тус сургалтыг дүүргэсэн цэргийн алба хаагчид “Монголын ресторан зоогийн газрын холбоо”-ны гишүүн байгууллага 2500 гаруй ресторанд ажиллаж болох давуу талтай аж.



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 256 ДУГААР АНГИЙН

ЦЭРГИЙН БАЙРНЫ ДЭЭВРИЙГ ЗАСВАРЛАВ



Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн түүхт 100 жилийн ойг тохиолдуулан цэргийн алба хаагчдын нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх зорилгоор тус ангийн танкийн батальоны цэргийн байрны дээврийг бүрэн засварлалаа.

Уг ажилд аймгийн Засаг даргын захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс 31.7 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд “Марзат арвай” ХХК-ий ажилчид

болон Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн орон сууцны алба, танкийн батальоноос томилогдсон бүрэлдэхүүн заагдсан хугацаанд чанартай гүйцэтгэж хүлээлгэн өгсөн юм. Түүнчлэн Өвөрхангай аймгийн Засаг дарга бөгөөд Батлан хамгаалах газрын дарга А.Ишдорж тус аймгийн нутаг дэвсгэрт байрлаж байгаа цэргийн анги, байгууллага, бие бүрэлдэхүүний албан үүргээ гүйцэтгэх нөхцөлийг хангах талаар хамтран ажиллаж, тал бүрийн дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн.

Дэд хурандаа Ч.АДЪЯА

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
200.274 +2433

ЭДГЭРСЭН
184.119 +1479

НАС БАРСАН
913 +6

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
4523 +80

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ
175 +28

ЭДГЭРСЭН
4261 +14

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 215,424,087

Эдгэрсэн

Нийт: 192,610,873

Нас барсан

Нийт: 4,487,255



“МОНГОЛ ХУРАНДАА” ЗУРГИЙН ЦОМОГ ТУН УДАХГҮЙ ...



МОНГОЛ ХУРАНДАА

“Монгол хурандаа” Нийгэмлэгийн 15 жилийн ойд зориулан гаргав.

“Монгол хурандаа нийгэмлэг” ТББ-аас “Монгол хурандаа” зургийн цомгийг эрхлэн гаргаж байна.

Энэхүү цомог нь Монгол Улсад хурандаа цол бий болсон 85 жилийн хугацаанд төрсөн 3200 гаруй хурандаа цолтны зураг, хурандаа цол хүртсэн тушаалыг нь хамтатган оруулсан

тайлбар бүхий анхны зурган цомог юм. Хурандаа нарын дунд алдар гавьяа, намтар түүхтэй олон хурандаа бий.

Т у х а й л б а л , Хөдөлмөрийн баатар, Төрийн соёрхолт, Гавьяат цолтон, үе залгамжилсан хурандаа цолтнууд байдгаас гадна ах дүү 4 хурандаа, өвөө, аав, хүү гээд 3 үеийн хурандаа,

эхнэр нөхөр, эгч дүү зэрэг хурандаа цолтнууд хэд хэд төрөн гарчээ. “Монгол хурандаа нийгэмлэг” ТББ-аас хурандаа нарын ажил хөдөлмөрөөс гадна, амьдрал, түүх намтрыг нь алдаршуулан сурталчлах зорилготой энэхүү зургийн цомгийг хурандаа цол бий болсны 85 жилийн ойд зориулж байгаа юм.

ӨНӨӨДРӨӨС ЭХЛЭН ОРОН НУТАГ РУУ ГАЛТ ТЭРЭГ ХЭВИЙН ЯВЖ ЭХЭЛНЭ

Өнөөдөр буюу 2021.08.27-ны өдрөөс эхлэн орон нутгууд руу чиглэсэн галт тэрэгний хөдөлгөөн хэвийн явж эхэлнэ.

Т у х а й л б а л , Улаанбаатар-Сүхбаатар-Улаанбаатар, Улаанбаатар-Дархан-Эрдэнэт-Дархан-Улаанбаатар, Улаанбаатар-Чойр-Улаанбаатар чиглэлийн зорчигчийн галт тэрэгний хөдөлгөөнийг хэвийн явуулж эхлэх аж.



ЦЭРГИЙН АЖИГЛАГЧ ОФИЦЕР, СЕКТОР КОМАНДЛАГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 2021-2022 онд үүрэг гүйцэтгэх цэргийн ажиглагч офицер, сектор командлагчийн сонгон шалгаруулалтыг 2021 оны 9 дүгээр сарын 20-24-ний өдрүүдэд зохион байгуулна.

С о н г о н шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагчид 2021 онд шинээр батлагдсан “ЭНХИЙГ ДЭМЖИХ А Ж И Л Л А Г А А Н Д ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ”-тай танилцаж,

НҮБ-ын цэргийн штабын тавигдах хангасан байх ба ЗХЖШ-ын АУГ-ын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэст доорх материалыг бүрдүүлэн 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ. Үүнд:

1. Харьяа анги, байгууллага, төрлийн цэргийн командлал болон ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн удирдлагын зөвшөөрсөн цохолттой хувийн өргөдөл;
2. Ажил байдлын тодорхойлолт;
3. Ж о л о о н ы

үнэмлэхийн хуулбар; 4.Цэргийн ажиглагч, штабын офицерын сургалт, дамжаа дүүргэсэн сертификатын хуулбар; 5. Сүүлийн 3 сарын дотор авхуулсан 4x6 хэмжээтэй цээж зураг 2 хувь;

6. Товч судалгаа; 7.Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт. Жич: Шаардлагатай нэмэлт мэдээллийг АУГ-ын ЭДАХ-ийн psod@mail.gov.mn цахим шуудангаар болон /3203, 92115982, 92096622/-тэй холбогдож тодруулж болно.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын төв штабт дараах ажлын байранд үүрэг гүйцэтгэх (P-3, P-4, P-5) сонирхолтой офицеруудын сонгон шалгаруулалтыг 2021 оны 9 дүгээр сарын 1-3-ны өдрүүдэд зохион байгуулна. Үүнд:

- Сургалтын офицер P-4
- Дүн шинжилгээний офицер P-3
- Сургалтын офицер P-3
- Дүн шинжилгээний офицер P-4
- Энхийг сахиулах ажиллагаа хариуцсан

офицер P-4 -Төлөвлөлтийн офицер P-4 (Хүний нөөц, бодлого төлөвлөлт) -Холбогч офицер P-4 -Цэргийн зөвлөхийн туслах P-5 -Ахлах холбогч офицер P-5

С о н г о н ш а л г а р у у л а л т а д хамрагдах хүсэлтэй цэргийн алба хаагчид 2021 онд шинээр батлагдсан “ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ”-ыг судлан

танилцаж, НҮБ-ын штабын ажилтанд тавигдах шаардлагыг хангасан байх ба ЗХЖШ-ын АУГ-ын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэст 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор харьяа командлал, газар, хэлтсээр дамжуулан саналаа ирүүлнэ. Холбогдох албан тушаалын жагсаалт, тавигдах шаардлага, дэлгэрэнгүй мэдээллийг psod@mail.gov.mn цахим мэйл хаягаар болон 3203, 92115982, 92096622 утсаар холбогдож тодруулж болно.

ДУГУЙН СПОРТООР ХИЧЭЭЛЛЭХИЙГ УРИАЛЛАА

Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургууль үүсэн байгуулагдсаны 100 жилийн түүхт ойн өдрийг угтаж Батлан хамгаалахын мэргэжил сургалт-үйлдвэрлэлийн төв /хуучнаар Ахлагчийн сургууль/-ийн удирдлага, хамт олон УБХИС-ийн офицер, ахлагч, багш, ажилчдын бие бялдраа хөгжүүлэх, бүтээлч санаачилга, нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор сургуулийнхаа шалган нэвтрүүлэх цэгт стандартад нийцсэн дугуйн зогсоолыг хийж дугуйн спортоор хичээллэн эрүүл мэнд бие бялдраа хөгжүүлж

их хотынхоо замын түгжрэл, утааг бууруулахад өөрсдийн хувь нэмрээ оруулж байна. Тус дугуйн зогсоолыг Батлан хамгаалахын

мэргэжил сургалт-үйлдвэрлэлийн төв болон Монголын дугуйн холбоо, "E-LEVEL"-ын багийн хамт олны хүчээр бүтээн байгуулжээ.



0-16 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙГ ЭМЧЛЭХ НЭГ САРЫН АЯН ЗАРЛАЖЭЭ



Нийслэлийн Шүд, эрүү, нүүрний төвөөс хичээлийн шинэ жил эхэлж буйтай холбогдуулан 0-16 насны хүүхдүүдийн нүүр, амны эмчилгээний нэг сарын аяныг өчигдрөөс эхлүүлжээ. Ингэснээр долоо хоногийн Даваа-Пүрэв гарагт хүүхдээ үзүүлэх боломжтойг

тус төвөөс мэдээллээ. Эцэг, эхчүүд хүүхдээ үзүүлэх цагаа dentalcenter.mn цахим хуудсаар авах бөгөөд аян 9 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл үргэлжилнэ. Асууж лавлах зүйл байвал ажлын цагаар 70112247 утсаар холбогдохыг зөвлөлөө. Тус төв нь Улаанбаатар

хотын хэмжээнд шүдний төрөлжсөн нүүр амны мэс засал, нүүр амны эмчилгээ, нүүр амны согог, гажиг засал чиглэлээр цогц тусламж үзүүлдэг мэргэжлийн байгууллага юм. Тус төв Баянзүрх дүүргийн гуравдугаар хороо, 12 дугаар хороололд байрладаг.

АВТОМАШИНГҮЙ ӨДӨР ЗАРИМ ЗАМД ХӨДӨЛГӨӨНИЙ ХЯЗГААРЛАЛТ ХИЙНЭ



Нийслэл хотын авто замын түгжрэлийг бууруулах болон хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан 8 дугаар сарын 28, 29-ний Бямба, Ням гарагт тээврийн хэрэгслийг улсын дугаарын тэгш, сондгойгоор хөдөлгөөнд оролцуулах шийдвэр гарсныг ТЦА-наас дахин санууллаа.

И н г э с н э э р Энхтайваны өргөн чөлөө буюу Баруун дөрвөн замаас Зүүн дөрвөн замын хооронд автомашингүй байна. Мөн Чингэлтэй, Баянзүрх, Сүхбаатар дүүргийн зарим замд хөдөлгөөний хязгаарлалт тогтоох аж. Энэ хугацаанд авто

замын зорчих хэсэгт 09:00-19:00 цагийн хооронд хичээлийн хэрэгсэл, сурагчийн дүрэмт хувцас бусад хувцас хэрэгслийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулах бөгөөд аж ахуйн нэгж, иргэдээс түрээсийн төлбөр авахгүй, зөвхөн хог, цэвэрлэгээний хураамж авах юм.